ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ ХУВЬ

**ОЮУ ТОЛГОЙ ХХК**

**ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК**

**ТиЭйчАр ОЮУ ТОЛГОЙ ЛТД**

**болон**

**ОЮУ ТОЛГОЙ НИДЕРЛАНД БИ.ВИ**

**нарын хооронд байгуулсан**

**НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ГЭРЭЭ**

**2023 оны 10 дугаар сарын 02-ны өдөр**

"МахониЛиотта" ГХОХХН
ОРЧУУЛГЫН АЛБА
TRANSLATION BUREAU
MahoneyLiotta LLP
УЛААНБААТАР ХОТ ТТГ3225 ☎ 2094231

## ГАРЧИГ

**Зүйл заалт** **Хуудас**

1. Нэр томьёоны тодорхойлолт, тайлбар ..... 1
2. НӨОДТХНГ-нд оруулах нэмэлт, өөрчлөлтүүд ..... 1
3. LIBOR-ийг орлуулах ..... 2
4. Мэдэгдэл болон баталгаа ..... 2
5. Үйлчлэх хууль ..... 2
6. Бусад заалт ..... 2

Хавсралт 1 НӨОДТХНГ-НД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТҮҮД ..... 4

OYU TOLGOI LLC
ОЮУ ТОЛГОЙ ХХК

ОЮУ ТОЛГОЙ
ХХ КОМПАНИ

**ЭНЭХҮҮ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ГЭРЭЭ** (энэхүү "**Гэрээ**" гэх)-г 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдөр дараах талуудын хооронд байгуулав:

(1) **Оюу Толгой ХХК** (хуучин нэрээр Айвенхоу Майнз Монголия Инк ХХК) – Компанийн тухай Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компани (цаашид **"Компани"** гэх);

(2) **Эрдэнэс Оюу Толгой ХХК** – Компанийн тухай Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан Төрийн өмчит компани (цаашид **"ТӨК"** гэх);

(3) **ТиЭйчАр Оюу Толгой Лтд** (хуучин нэрээр Айвенхоу Оюу Толгой (БиВиАй) Лтд) – Роуд Таун, Тортола, Британийн Виржинийн Арлууд гэх хаягт байрлах, Британийн Виржинийн Арлуудын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компани (цаашид **"АйВиЭн"** гэх); болон

(4) **Оюу Толгой Нидерланд Би.Ви**., Юнит 02.01, Кингсфорвег 151, 1043 ЖиАр, Амстердам, Нидерланд гэх хаягт байрлах, Нидерланд Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компани (цаашид "**ОТН**" гэх).

**ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

(А) Энэхүү Гэрээ нь Компани, ОТН, АйВиЭн болон ТӨК нарын хооронд 2011 оны 6 дугаар сарын 8-ны өдөр байгуулсан Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон Хувь нийлүүлэгчдийн Гэрээ (цаашид **"НӨОДТХНГ"** гэх)-нд хамаарна.

(Б) 2012 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр ТӨК нь Компанийн хувьцаа эзэмшигчээр бүртгүүлж, Эрдэнэс МГЛ ХХК-ийн оронд НӨОДТХНГ-ний нэг тал болсон болно.

(В) Талууд НӨОДТХНГ-ний холбогдох хүүгийн төлбөрийн хувийг тооцох тооцооллын суурийг LIBOR (энэхүү Гэрээний нөхцөлийн дагуу нэмэлт, өөрчлөлт оруулахын өмнөх НӨОДТХНГ-нд тодорхойлсон)-аас Жишиг хүүгийн хувьд шилжүүлж, НӨОДТХНГ-нд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тохиролцов.

**ИЙМД,** дээр дурдсан үндэслэл болон бусад нөхцөл, болзлыг харгалзан үзэж, хүлээн зөвшөөрсний үндсэн дээр дараах байдлаар **ТОХИРОЛЦОВ**.

## 1. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ, ТАЙЛБАР

### 1.1 Тодорхойлолт

Агуулгаасаа хамааран энэхүү Гэрээнд өөр утга илэрхийлэхээс бусад тохиолдолд НӨОДТХНГ (энэхүү Гэрээгээр нэмэлт өөрчлөлт оруулсан)-нд тодорхойлсон буюу ашигласан нэр томьёог энэхүү Гэрээнд ижил утгаар ойлгоно. НӨОДТХНГ-г энэхүү Гэрээтэй нэгдмэл, нэг баримт бичигт тооцож, тайлбарлана. Түүнчлэн энэхүү Гэрээнд:

**"Хүчин төгөлдөр болох өдөр"** гэдэгт 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийг; мөн

**"Тал"** гэдэгт энэхүү Гэрээний аль нэг тал гэж тус тус ойлгоно.

## 2. НӨОДТХНГ-НД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТҮҮД

Энэхүү Гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу Талууд (НӨОДТХНГ-ний 24.6-р зүйл (*Нэмэлт өөрчлөлт*)-д зааснаар) Хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн Хавсралт 1 (*НӨОДТХНГ-нд оруулах Нэмэлт, өөрчлөлтүүд)*-д тусгасан нэмэлт, өөрчлөлтүүдийг НӨОДТХНГ-нд оруулахыг зөвшөөрч байна. Улмаар НӨОДТХНГ-нд заасан Талуудын эрх, үүргийг Хүчин төгөлдөр болох өдөр болон тухайн өдрөөс эхлэн энэхүү Гэрээгээр нэмэлт, өөрчлөлт оруулсан НӨОДТХНГ-ний нөхцөлөөр зохицуулж, түүнд нийцүүлэн тайлбарлана. Энэхүү Гэрээгээр нэмэлт, өөрчлөлт оруулаагүй НӨОДТХНГ-ний заалтууд аливаа өөрчлөлтгүйгээр хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

## 3. LIBOR-ИЙГ ОРЛУУЛАХ

2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тооцогдох хүүгийн хугацаа тус бүрийн хувьд Санхүүжүүлсэн дүн, Үлдэгдэл төлбөр, Хувь нийлүүлэгчийн өр, Хувь нийлүүлэгчийн одоогийн зээл болон тэдгээрийн хуримтлагдсан аливаа хүүнд тооцох жишиг хүүгийн хувийг тухайн хүүгийн хугацаа 2023 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөр дуусах хүртэл LIBOR (энэхүү Гэрээний нөхцөлийн дагуу нэмэлт, өөрчлөлт оруулахаас өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан НӨОДТХНГ-ний нөхцөлд заасны дагуу)-д үндэслэн тооцно.

2023 оны 10 дугаар сарын 1 болон түүнээс хойш эхлэх хүүгийн бүх хугацаанд хүү тооцох хугацаа бүрд хамаарах жишиг хүүг энэхүү Гэрээгээр нэмэлт, өөрчлөлт оруулсан НӨОДТХНГ-ний дагуу тодорхойлсон Жишиг хүүгийн хувь хэмжээгээр тооцно.

## 4. МЭДЭГДЭЛ БОЛОН БАТАЛГАА

4.1 Гэрээний Тал тус бүр нөгөө Талдаа дараахь мэдэгдэл болон баталгааг гаргаж байна. Үүнд:

(а) тухайн Тал нь өөрийн үүсгэн байгуулагдсан улсынхаа хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй компани (ба ТӨК-ийн хувьд Компанийн тухай Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан бөгөөд энэ хуулийн дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулна); мөн

(б) энэхүү Гэрээг байгуулах болон Гэрээнд заасан өөрийн үүргээ биелүүлэх, үйл ажиллагаагаа одоо эрхлэн явуулж буй байдлаар нь, эсхүл ирээдүйд төлөвлөснөөр явуулах бүрэн эрхтэй.

## 5. ҮЙЛЧЛЭХ ХУУЛЬ

Энэхүү Гэрээ болон түүнтэй холбогдон үүссэн гэрээний бус аливаа үүргийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулж, тайлбарлана.

## 6. БУСАД ЗААЛТ

6.1 Энэхүү Гэрээний аль нэг заалт нь аливаа хуулийн дагуу хүчин төгөлдөр бус, хууль бус эсхүл хэрэгжих боломжгүй болсон тохиолдолд энэ нь үлдсэн заалтуудын хүчин

төгөлдөр байдал, хууль ёсны байдал болон хэрэгжилтэд аливаа байдлаар нөлөөлөхгүй.

6.2 Энэхүү Гэрээг хэд хэдэн хувь үйлдэж болох бөгөөд тэдгээр хувиуд нь Талууд гэрээний нэг хувь дээр гарын үсэг зурсантай ижил хүчин төгөлдөр байна.

6.3 НӨОДТХНГ-ний 24.1 (*Мэдэгдэл*), 24.8 (*Гэрээний хэл*) болон 23 (*Маргаан шийдвэрлэх*) заалтуудыг *mutatis mutandis* байдлаар буюу холбогдох өөрчлөлттэйгөөр тодорхой заасан байдлаар энэхүү Гэрээнд тусгасан гэж үзнэ.

**Энэхүү Гэрээний эхэнд заасан өдөр Гэрээг байгуулсан болно.**

## Хавсралт 1
## НӨОДТХНГ-НД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТҮҮД

1.

1.1 11.3(д)(i) дэх заалтыг бүхэлд нь хасаж, оронд нь дараах агуулгатай заалт оруулав. Үүнд:

*(i)* *"Хуанлийн улирлын **Санхүүжилтийн хүүгийн хувь** гэж:*

*(A)* *Хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн Хөрвүүлэх өдрийн өмнөх өдөр хүртэлх хугацааны хувьд хуанлийн Улирлын хүүг хэлэх бөгөөд энэ нь жилийн 9,9 хувь бодит хувьтай тэнцэх бөгөөд;*

*(Б)* *13.3-т заасныг харгалзан Хөрвүүлэх өдөр болон түүнээс хойшхи хугацааны хувьд холбогдох Улиралд Жишиг хүүгийн хувь дээр нэмэх нь 6.50 хувь байна;*

*Эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс, тодруулбал 11.3(д)(i)(Б)-д заасан Жишиг хүүгийн хувь (холбогдох Улирлын) дээр нэмэх нь 6.50 хувь нь жилийн бодит хүү байна."*

1.2 13.1(г)(ii) заалтыг бүхэлд нь хасаж, оронд нь дараах агуулгатай заалт оруулав. Үүнд:

*(ii)* *"13.3-р заалтыг харгалзан, Хөрвүүлэх өдөр болон түүнээс хойшхи хугацааны хувьд хуанлийн Улиралд Жишиг хүүгийн хувь дээр нэмэх нь 6.50 хувь.*

*Эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс, тодруулбал 13.1(г)(ii)-д заасан Жишиг хүүгийн хувь (холбогдох Улирлын) дээр нэмэх нь 6.50 хувь нь жилийн бодит хүү байна."*

1.3 13.2 *(Хувь нийлүүлэгчдийн зээлийг тэргүүн ээлжинд эргүүлэн төлөх)* заалтын дараа 13.3 *(СМЕ хугацаат SOFR-ийг ашиглах боломжгүй байх)* болон 13.4 *(Санхүүжилтийн өртөг)* заалтуудыг шинээр нэмж оруулав.

***"13.3 СМЕ хугацаат SOFR-ийг ашиглах боломжгүй байх***

(а) *<u>Интерполяцласан СМЕ хугацаат SOFR</u>: Хэрэв Санхүүжүүлсэн дүн, Үлдэгдэл төлбөр, Хувь нийлүүлэгчийн өр, Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийн хүүгийн хугацаанд СМЕ хугацаат SOFR тооцох боломжгүй бол холбогдох Жишиг хүүгийн хувь нь тухайн Санхүүжүүлсэн дүн, Үлдэгдэл төлбөр, Хувь нийлүүлэгчийн өр, Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийн хүүгийн хугацаатай тэнцэх хугацааны Интерполяцласан СМЕ хугацаат SOFR байна.*

(б) *<u>Түүхэн жишиг хүү</u>: Хэрэв Санхүүжүүлсэн дүн, Үлдэгдэл төлбөр, Хувь нийлүүлэгчийн өр болон Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийн хүүгийн хугацаанд СМЕ хугацаат SOFR тооцох боломжгүй бөгөөд Интерполяцласан СМЕ хугацаат SOFR-ийг тооцоолох боломжгүй бол холбогдох Жишиг хүү нь тухайн Санхүүжүүлсэн дүн, Үлдэгдэл төлбөр, Хувь нийлүүлэгчийн өр, Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийн хувьд Түүхэн СМЕ хугацаат SOFR байна.*

(в) *<u>Төв банкны тогтмол хүү:</u> Хэрэв Санхүүжүүлсэн дүн, Үлдэгдэл төлбөр, Хувь нийлүүлэгчийн өр, Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийн хүүгийн хугацаанд СМЕ хугацаат SOFR тооцох боломжгүй бөгөөд Интерполяцласан СМЕ хугацаат SOFR болон Түүхэн СМЕ хугацаат SOFR-ийг тооцоолох боломжгүй бол холбогдох Жишиг хүүгийн хувь нь:*

(1) *дараах зүйлүүдийн нийлбэрээр тооцох жилийн хүүгийн хувь байна. Үүнд:*

(А) *Хүүгийн түвшин зарлах өдрийн Төв банкны хүү; болон*

(Б) *холбогдох Төв банкны хүүгийн тохируулга; эсхүл*

(2) *Хүүгийн түвшин зарлах өдрийн Төв банкны хүү байхгүй тохиолдолд дараах зүйлүүдийн нийлбэрээр тооцох жилийн хүүгийн хувь байна. Үүнд:*

(А) *Хүүгийн түвшин зарлах өдрөөс тав (5)-аас илүүгүй хоног доторх Төв банкны хамгийн сүүлийн хүү; болон*

(Б) *холбогдох Төв банкны хүүгийн тохируулга.*

(г) *Дээр дурдсан (в) заалт хэрэгжих үед холбогдох Төв банкны хүү байхгүй бол (энэ нь **Төв банкны үйл ажиллагааны тасалдал** болно) тухайн хүүгийн хугацаанд Санхүүжүүлсэн дүн, Үлдэгдэл төлбөр, Хувь нийлүүлэгчийн өр болон Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийн хувьд доорх 13.4 (Санхүүжилтийн өртөг)-р заалт үйлчилнэ.*

***13.4 Санхүүжилтийн өртөг***

(а) *Төв банкны үйл ажиллагааг тасалдуулсан үйл явдал тохиолдсон бол Хувь нийлүүлэгчид уг үйл явдлын талаар Компанид нэн даруй мэдэгдэнэ. Хэрэв Хувь нийлүүлэгчид Төв банкны үйл ажиллагааны тасалдлын тухай Компанид мэдэгдсэн бол Хувь нийлүүлэгчид Төв банкны үйл ажиллагаа тасалдсан үйл явдал зогссон тухай мэдэгдлийг Компанид өгөх хүртэл:*

*(i) Санхүүжүүлсэн дүн, Үлдэгдэл төлбөр, Хувь нийлүүлэгчийн өр болон Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлд дараах зүйлсүүдийн нийлбэртэй тэнцүү хэмжээний хүү хуримтлагдана. Үүнд:*

*(А) холбогдох Улирал тутам 6.50%; болон*

*(Б) Хувь нийлүүлэгчдээс Компанид аль болох боломжит хугацаанд гэхдээ ямар ч тохиолдолд холбогдох хүүгийн хугацааны хамаарах хүү төлөх өдрөөс Ажлын гурваас ихгүй өдрийн өмнө мэдэгдсэний дагуу, Хувь нийлүүлэгчдийн үндэслэлтэйгээр сонгож болох аливаа эх үүсвэрээс тухайн Санхүүжүүлсэн дүн, Үлдэгдэл төлбөр, Хувь нийлүүлэгчийн өр эсхүл Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийг санхүүжүүлсэнтэй холбоотойгоор Хувь нийлүүлэгчдийн гаргах санхүүжилтийн өртгийн жилийн хувиар илэрхийлсэн хүү.*

(б) *13.4(а)-д хэрхэн зохицуулснаас үл хамаарч, Төв банкны үйл ажиллагааг тасалдуулсан үйл явдал тохиолдсон бөгөөд Хувь нийлүүлэгчид эсхүл Компани шаардсан тохиолдолд 13.4(а)-д заасны дагуу Хувь нийлүүлэгчид энэ талаар мэдэгдсэнээс хойш Ажлын таван (5) өдрийн дотор Хувь нийлүүлэгчид болон Компани нь холбогдох Санхүүжүүлсэн дүн, Үлдэгдэл төлбөр, Хувь нийлүүлэгчийн өр эсхүл Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлд хамаарах хүүгийн хэмжээг тодорхойлоход ашиглах орлуулах суурийг тохиролцох зорилгоор (гуч (30) хоногоос илүүгүй хугацаагаар) хэлэлцээр хийнэ.*

*Ийнхүү хэлэлцээж тохиролцсон аливаа орлуулах суурь нь холбогдох нөхцөлийн дагуу хүчинтэй болж, дээрх 13.4(а) зүйлд заасны дагуу мөрдөгдөж байсан хүүг орлоно. Хэрэв тохиролцоонд хүрч чадаагүй бол холбогдох Санхүүжүүлсэн дүн, Үлдэгдэл төлбөр, Хувь нийлүүлэгчийн өр эсхүл Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлд хамаарах хүүг 13.4(а)(i)-д заасны дагуу тооцно."*

1.4 25 дугаар зүйл *(Нэр томьёоны тодорхойлолт)*-д дараах шинэ тодорхойлолтуудыг цагаан толгойн үсгийн дарааллаар нэмж оруулав. Үүнд:

***" Төв банкны хүү** гэж:*

(а) *Нью-Йоркийн Холбооны Нөөцийн Банкнаас тухай бүр нийтэлдэг, АНУ-ын Холбооны Нээлттэй Зах зээлийн Хорооноос тогтоосон богино хугацааны хүүгийн зорилтот түвшинг; эсхүл*

(б) *хэрэв энэхүү зорилтот түвшин нь нэг оронтой тоо биш бол дараахийн дунджийг хэлнэ:*

(i) *АНУ-ын Холбооны Нээлттэй Зах зээлийн Хорооноос тогтоосон, Нью-Йоркийн Холбооны Нөөцийн Банкнаас нийтэлсэн богино хугацааны хүүгийн зорилтот түвшний дээд хязгаар; болон*

(ii) *тухайн зорилтот түвшний доод хязгаар.*

***Төв банкны хүүгийн тохируулга** гэдэг нь АНУ-ын Засгийн газрын үнэт цаасны ажлын өдөр дуусах үед давамгайлж буй Төв банкны хүүгийн хувьд, АНУ-ын Засгийн газрын үнэт цаасны өмнөх таван (5) ажлын өдрийн, СМЕ хугацаат SOFR-ийг ашиглах боломжтой Төв банкны хүүгийн спрейд тохируулгын арифметик дунджийг 20 хувиар бууруулсан дүнг хэлнэ.*

***Төв банкны хүүгийн спрейд тохируулга** гэж АНУ-ын Засгийн газрын үнэт цаасны аливаа ажлын өдрийн хувьд, дараахын зөрүүг (жилийн хувиар илэрхийлсэн) хэлнэ. Үүнд:*

(а) *АНУ-ын Засгийн газрын үнэт цаасны тухайн ажлын өдөрт хамаарах СМЕ хугацаат SOFR; болон*

(б) *АНУ-ын Засгийн газрын үнэт цаасны тухайн ажлын өдөр дуусах үед давамгайлж байсан Төв банкны хүү.*

***СМЕ хугацаат SOFR** гэж СиЭмИ Групп Бенчмарк Администрейшн Лимитедээс (эсхүл уг хүүг нийтлэх эрх бүхий аливаа бусад этгээдээс) тухайн холбогдох хугацаанд хамааруулан нийтэлсэн, СиЭмИ Групп Бенчмарк Администрейшн Лимитед (эсхүл уг хүүг удирдан зохицуулах эрхийг хүлээн авсан аливаа бусад этгээд)-ийн зохицуулж буй гурван сарын хугацаат SOFR жишиг хүүг хэлнэ.*

***Зээлийн тохируулгын спрейд** гэж 0.26161% -тай тэнцэх жилийн хүүг хэлнэ.*

***Түүхэн СМЕ хугацаат SOFR** гэж аливаа Санхүүжүүлсэн дүн, Үлдэгдэл төлбөр, Хувь нийлүүлэгчийн өр эсхүл Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийн хувьд, тухайн Санхүүжүүлсэн дүн, Үлдэгдэл төлбөр, Хувь нийлүүлэгчийн өр эсхүл Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийн хүүгийн хугацаатай тэнцэх хугацаанд хамаарах, Хүүгийн түвшин зарлах өдрөөс өмнөх АНУ-ын Засгийн газрын үнэт цаасны ажлын таваас (5) илүүгүй өдрийн доторх хамгийн сүүлд хэрэгжиж буй СМЕ хугацаат SOFR-ийг хэлнэ.*

***Интерполяцласан СМЕ хугацаат SOFR** гэж аливаа Санхүүжүүлсэн дүн, Үлдэгдэл төлбөр, Хувь нийлүүлэгчдийн зээл эсхүл Хувь нийлүүлэгчийн өр эсхүл Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийн аливаа хүүгийн хугацааны хувьд, дараах зүйлүүдийн хооронд хийсэн шугаман интерполяцийн үр дүнд бий болох хувь хэмжээ (СМЕ хугацаат SOFR-тай ижил аравтын орон хүртэл бүхэлдсэн дүн)-г хэлнэ:*

(а) *Дараахийн аль нэг:*

(i) *тухайн Санхүүжүүлсэн дүн, Үлдэгдэл төлбөр, Хувь нийлүүлэгчийн өр эсхүл Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийн хүүгийн хугацаанаас бага байх хамгийн урт хугацаа*

*(СМЕ хугацаат SOFR тооцох боломжит)-нд хамаарах СМЕ хугацаат SOFR (Хүүгийн түвшин зарлах өдрийн 11:00 цаг (Лондонгийн цагаар)-ийн байдлаар); эсхүл*

*(ii) Хэрэв тухайн Санхүүжүүлсэн дүн, Үлдэгдэл төлбөр, Хувь нийлүүлэгчийн өр эсхүл Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийн хүүгийн хугацаанаас бага хугацаанд ийнхүү СМЕ хугацаат SOFR тооцох боломжгүй бол Хүүгийн түвшин зарлах өдрөөс АНУ-ын Засгийн газрын үнэт цаасны ажлын хоёр өдрийн өмнөх SOFR; болон*

(б) *тухайн Санхүүжүүлсэн дүн, Үлдэгдэл төлбөр, Хувь нийлүүлэгчийн өр эсхүл Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийн хүүгийн хугацаанаас хэтэрсэн хамгийн богино хугацаа (СМЕ хугацаат SOFR тооцох боломжит)-нд хамаарах СМЕ хугацаат SOFR (хүүгийн түвшин зарлах өдрийн Лондонгийн цагаар өглөөний 11:00 цагийн байдлаар).*

***Хүүгийн түвшин зарлах өдөр*** *гэдэг нь хүүгийн түвшин тогтоох аливаа хугацааны хувьд:*

(а) *доорх (б)-д заасны дагуу тухайн хугацааны эхний өдрөөс (холбогдох синдикат зээлийн зах зээлд өөр жишиг мөрдөгддөг бол Хүүгийн түвшин зарлах өдрийг тухайн зах зээлийн жишигт нийцүүлэн Хувь нийлүүлэгчид тогтооно (хэрэв хүүгийн түвшнийг ихэвчлэн нэгээс дээш өдөр зарладаг бол эдгээр өдрүүдийн сүүлийн өдөр байна)) өмнөх АНУ-ын Засгийн газрын үнэт цаасны ажлын хоёр (2) өдөр; эсхүл*

(б) *хэрэв Жишиг хүүгийн хувь нь Төв банкны хүүтэй адил эсхүл түүнд үндэслэсэн бол тухайн хугацааны эхний өдрөөс өмнөх АНУ-ын Засгийн газрын үнэт цаасны ажлын хоёр (2) өдрийг хэлнэ.*

***Жишиг хүүгийн хувь*** *гэдэг нь аливаа Санхүүжүүлсэн дүн, Үлдэгдэл төлбөр, Хувь нийлүүлэгчийн өр эсхүл Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийн хүүгийн хугацааны хувьд жилийн хувиар илэрхийлэгдсэн, дараах зүйлсүүдийн нийлбэрийг хэлнэ. Үүнд:*

(а) *Дор дурдсаны дагуу тодорхойлсон хувийн аль нэг:*

*(i) Хүүгийн түвшин зарлах өдрийн Лондонгийн цагаар өглөөний 11:00 цагийн байдлаар тухайн Санхүүжүүлсэн дүн, Үлдэгдэл төлбөр, Хувь нийлүүлэгчийн өр эсхүл Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийн хүүгийн хугацаатай тэнцэх хугацаанд хамаарах СМЕ хугацаат SOFR; эсхүл*

*(ii) 13.3 (СМЕ хугацаат SOFR-ийг ашиглах боломжгүй байх)-д заасны дагуу өөрөөр тодорхойлсон; болон*

(б) *дээрх (i) дахь хэсэг ба (13.3 зүйл (СМЕ хугацаат SOFR-ийг ашиглах боломжгүй байх)-ийн (а) болон (б)-д заасан тодорхойлолтод хамаарах тул) (ii) дахь хэсэгт заасан тохиолдолд Зээлийн тохируулгын спрейд,*

*Хэрэв дээрх нийлбэр нь тэгээс бага бол Жишиг хүүгийн хувийг тэг гэж үзнэ.*

***SOFR*** *гэж Нью Йоркийн Холбооны Нөөцийн Банкнаас (эсхүл энэ үүргийг хүлээсэн өөр этгээдээс) нийтэлсэн, Нью-Йоркийн Холбооны Нөөцийн Банкнаас (эсхүл энэ хүүг хариуцаж буй бусад этгээдээс) удирддаг баталгаат овернайт буюу нэг өдрийн санхүүжилтийн жишиг хүүг (SOFR) хэлнэ.*

***АНУ-ын Засгийн газрын үнэт цаасны Ажлын өдөр*** *гэж доорхоос бусад өдрийг хэлнэ:*

(а) *Бямба, Ням гараг;*

(б) *Үнэт цаасны салбар, Санхүүгийн зах зээлийн холбоо (эсхүл түүний эрхийг залгамжлан авагч аливаа байгууллага)-ын зүгээс АНУ-ын Засгийн газрын үнэт цаасыг арилжаалах зорилгоор гишүүдийнхээ тогтмол орлогын хэлтсүүдийг бүтэн өдрийн турш хаахыг зөвлөсөн өдөр."*

1.5 *"Хувь нийлүүлэгчийн одоогийн зээл"* гэсэн тодорхойлолтыг бүхэлд нь хасаж, оронд нь дараах агуулгатай заалт оруулав.

***Хувь нийлүүлэгчийн одоогийн зээл*** *гэж Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр хүртэлх хугацаанд Оюу толгой төсөл болон Үндсэн үйл ажиллагаатай холбогдуулан Айвенхоу групп, эсхүл Рио Тинто группээс Компанид урьдчилан олгосон бүх санхүүжилт (дүнг Хөрөнгө оруулалтын гэрээний 15.7.5 дахь заалтын дагуу тодорхойлно) (тухайн санхүүжилтийг олгосон нөхцөл болон түүнийг Компани Үйл ажиллагааны зардал, эсхүл Үндсэн хөрөнгийн зардалд зарцуулсан эсэхээс үл хамааран) түүнд тооцогдох хүүг энэхүү Гэрээний 9.8-д заасны дагуу тооцсоныг хэлэх бөгөөд үүнд:*

(а) *Хүчин төгөлдөр болох өдөр болон уг өдрөөс хойш санхүүжилтийн дүнд 9,9 хувиар тооцсон жилийн бодит хүү багтана. Чингэхдээ энэ хүү нь АНУ-ын Хэрэглээний Үнийн Индексийн өмнөх Улирлын хэлбэлзлийн хувиар улирал тутам тогтоодог хувиудын нийлбэрээр тодорхойлогдоно.*

(б) *13.3-р заалтыг харгалзан, Хөрвүүлэх өдөр болон түүнээс хойш Жишиг хүүгийн хувь (холбогдох улирлын) дээр нэмэх нь 6.5% (энэ нь жилийн бодит хүү байна) багтана."*

1.6 "LIBOR"-ын тодорхойлолтыг бүхэлд нь хасав.

1.7 24.1(б)(i) ба (ii) заалтыг бүхэлд нь хасаж, оронд нь дараах агуулгатай заалт оруулав:

(i) *ТӨК-д*:

Монгол Улс
Улаанбаатар 14240
Сүхбаатар дүүрэг,
Чингисийн өргөн чөлөө 15
Моннис цамхаг, 14-р давхар,
Эрдэнэс Оюу Толгой ХХК
Хүлээн авагч: Гүйцэтгэх захирал
Факсын дугаар: 976 70078085

(ii) Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид:

*АйВиЭн-д:*
ТиЭйчАр Оюу Толгой Лтд
Рөүд Таун
Тортола ВиЖи1110
Британийн Виржинийн арлууд
Хүлээн авагч: Захирал

*ОТН-д:*
Оюу Толгой Нидерланд Би.Ви
Юнит 02.01, Кингсфорвег 151, 1043 ЖиАр,
Амстердам
Нидерланд Улс
Хүлээн авагч: Компанийн нарийн бичгийн дарга

Хувийг АйВиЭн / ОТН-д (аль хамаарах)
(мэдэгдэлд тооцохгүй):

Оюу Толгой ХХК-р дамжуулан
Монгол Улс
Улаанбаатар 14240
Сүхбаатар дүүрэг
Чингисийн өргөн чөлөө 15

Моннис цамхаг 12 давхар
Хүлээн авагч: Компанийн нарийн бичгийн дарга
мөн
Хувийг (мэдэгдэлд тооцохгүй):
Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед:
6 Сейнт Жеймсийн талбай
Вестминстер
Лондон SW1Y 4AD
Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
Хүлээн авагч: Компанийн нарийн бичгийн дарга

## ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ ХУУДАС

**ОЮУ ТОЛГОЙ ХХК**

**Оюу Толгой ХХК-ийг төлөөлж**, гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан Дэйрдрэ Лингенфэлдер:

Гарын үсэг

Гүйцэтгэх захирал
Албан тушаал

**ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК**

**Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийг төлөөлж**, гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан

Н.Цэрэнбат :

ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК 5548721 СБА9488 УЛААНБААТАР ХОТ

Гарын үсэг

Гүйцэтгэх захирал

Албан тушаал

**ОЮУ ТОЛГОЙ НИДЕРЛАНД БИ.ВИ**

**Оюу Толгой Нидерланд Би.Ви-ийг төлөөлж**, гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан Жэй. Пи. Киддл:




Гарын үсэг

Гүйцэтгэх захирал А

Албан тушаал

**ОЮУ ТОЛГОЙ НИДЕРЛАНД БИ.ВИ**

**Оюу Толгой Нидерланд Би.Ви-ийг төлөөлж**, гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан Эйч. Би. Эйч. Краак:



Гарын үсэг

Гүйцэтгэх захирал Б

Албан тушаал

**ТиЭйчАр ОЮУ ТОЛГОЙ ЛТД**

**ТиЭйчАр Оюу Толгой Лтд-г төлөөлж,** гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан Роберт Морган:

Гарын үсэг

Захирал

Албан тушаал